



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/67

Мөрөн сум

**Мал амьтны сэг зэм устгал, орчны
халдваргүйтгэлийн арга хэмжээг зохион
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.13 дахь заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.3.1, 7.3.2, 7.3.3, 7.3.4, 7.3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мал амьтны сэг зэмээс хүн малын халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор сэг зэмийг цуглуулж устгах, орчны халдваргүйтгэл хийх ажлыг 2025 оны 04 дугаар сарын 01-ээс 2025 оны 05 дугаар сарын 01-ийг хүртэл хугацаанд зохион байгуулсугай.

2.Мал, амьтны сэг зэм устгал, орчны халдваргүйтгэлийг мал амьтны эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох журам зааврын дагуу орон нутгийн байгууллага, малчид, иргэдийн оролцоотой зохион байгуулж, хүн хүч, шаардагдах зардал, тээврийн хэрэгслийн асуудлыг шийдвэрлэж ажиллахыг сумын тамгын газрын дарга (Н.Намжилноров) даалгасугай.

3.Мал, амьтны сэг зэмийн устгал, орчны халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулахад шаардлагатай халдваргүйтгэлийн бодис, хамгаалах хувцас хэрэгсэл, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн Улсын байцаагч (Т.Жавхлантөгс), Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Ш.Баасандорж), Мал, амьтны сэг зэмийн устгал, орчны халдваргүйтгэлийн арга хэмжээнд ажилгүй иргэдийг татан оролцуулах, түр ажлын байраар хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч төсөл хөтөлбөрийн хүрээнд ажлын хөлсийг холбогдох журмын дагуу олгохыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хяналтын Улсын байцаагч (Г.Загдхорол) нарт даалгасугай.

4.Дээрх арга хэмжээний хүрээнд хяналт тавин ажиллах онцгой комиссын гишүүдийн хуваарийг хавсралтаар баталсугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Мягмаржав)-д үүрэг болгосугай

ДАРГА  Н.ХАТАНБААТАР

Сумын Засаг даргын 2025 оны
...07 сарын 07 өдрийн .../07
дугаар захирамжийн хэсрэлт

ОНЦГОЙ КОМИССЫН ГИШҮҮДИЙН БАГ ХАРИУЦАН АЖИЛЛАХ ХУВААРЬ

Д/д	Багийн нэр	Онцгой комиссын гишүүдийн нэрс	Албан тушаал
1	Зөөлөн	Г.Загдхорол	ХЭХАХ-ийн мэргэжилтэн
2	Өлзийт	Н.Энхмягмар	Нийгмийн даатгалын Улсын байцаагч
3	Бүрээт	Ш.Баасандорж	Байгаль орчны хяналтын Улсын байцаагч
4	Цагаан толгой	Б.Мягмаржав	Засаг даргын орлогч
5	Чандган	Г.Хишигбаатар	Хууль эрх зүйн мэргэжилтэн